



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/316

Арвайхээр сум

Захирамжийн зарим хэсгийг хүчингүй
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 3 дугаар баг, Түгийн овооны ар хэсэгт Тайжууд овогт Доржпаламын Ядамсүрэн (КН83100361), Боржигон овогт Ганхуягийн Гантөмөр (ЙЮ05212214)-ийн гэр бүлийн хэрэгцээнд өмчилсөн газрыг хүчингүй болгосугай.

2. Дээрх газар өмчлөх эрх нь хүчингүй болсон иргэдийн мэдээлэл, нэгж талбарын хувийн хэргийг Тарагт суманд шилжүүлэхийг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд), Арвайхээр сумын Засаг дарга (Б.Ганбат) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын “Газар өмчлөх эрх хүчингүй болгох, газар өмчлүүлэх тухай” 2012 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/374 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтын 118 дахь дэс, “Газар өмчлүүлэх тухай” 2013 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн А/295 дугаар захирамжийн хавсралтын 31 дэх дэсийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0604

D:My Doc. Zahiramj. Zasag darga